

  
**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 95

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийлээ.

Аудитаар үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 158,011.00 /нэг дүн тавин найман мянган арван нэгэн/ төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, 14.4.6-д /бүх зардал/, 20.2.3-т /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хотож, санхүүгийн тайлан гаргах/ заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлэхгүй бол алдаа, зөрчлийг нягтлан бодох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/. Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийг эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврын дагуу хөтлөх

Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар т ирүүлэхийг Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн шууд захирагч Б.Алтантөгс, нягтлан бодогч Т.Одонцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР  Ч.ОЮУНДУЛАМ

**БАТАЛГААЖУУЛСАН**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Р.МӨНХТОГТОХ



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 206, 207, 210, 213 тоот  
7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090  
Утас: 70592439, 70592208, 70593208  
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2023. 02. 27 № 02/95  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗРЫН ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.АЛТАНТӨГС ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хүргүүлж байна. Албан шаардлагыг заасан хугацаанд хэрэгжүүлэн хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт ..... хуудас

ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

0012032260

*Т. Одооцугуул*  
*Зорилгоор*  
*арилгах*  
*албан шаардлагын*  
*харилцуу*  
*огох.*  
*В. бmf*  
*11/01*